



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар A/269

Улаанбаатар хот

Г Төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 46 дугаар тушаалаар батлагдсан "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам"-ын 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 9, 10 дугаар хороо "Дэнжийн 1000" орчим ХЕТ-2013-3 багцын 39,7 га "Б" хэсэгчилсэн талбайд төсөл хэрэгжүүлэгч "Эрэл" ХХК нь 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн Эвлэрлийн гэрээ болон Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/680 дугаар захирамжид заасан үүргийг биелүүлээгүй тул Хяналтын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02/03 дугаар хурлын шийдвэрийн дагуу тус компанийн төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцалсугай.

2. Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан хэсэгчилсэн талбайд төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Нийслэлийн Орон сууцны бодлогын газар (Г. Ганхүү)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б. Сүхбаатарт тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д. СУМЬЯАБАЗАР

111020001341